



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/115

Есөнбулаг

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсэг, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/178 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн шуурхай штабыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга (Г.Чинбат), Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц) нарт даалгасугай.

3. Цаг агаарын мэдээ, мэдээллийг тухай бүр нь олон нийтэд шуурхай мэдээлж шуурхай штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (Н.Алтантуяа), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
20²⁴ оны 06 дугаар сарын 07 -ны
өдрийн 415 дугаар захирамжийн
хавсралт

АЙМГИЙН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай штабын дарга:

Орлогч дарга:

Гишүүд:

(Аймгийн Засаг даргын орлогч)

(Онцгой байдлын газрын дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө

оруулалтын хэлтсийн

дарга)

(Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч)

(Цагдаагийн газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын дарга)

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын

газрын дарга)

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын

дарга)

(Авто тээврийн төвийн дарга)

(Улаан загалмайн хорооны дарга)

(“Ундарга-Алтай” орон нутгийн өмчит аж ахуйн

тооцоот үйлдвэрийн газрын захирал)

(Говь-Алтай-АЗЗАТӨХК-ны захирал)

(Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын

дарга)

(Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга:

(Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах

төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах

мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын

хяналтын байцаагч)